



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 73

Чойр

Хуулийн байгууллагуудын  
үйлчилгээний чанарыг сайжруулах,  
иргэдэд эрх зүйн мэдлэг олгох  
дэд хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

3. Дээрх хөтөлбөр батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.БАТЗАМ



## ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ИРГЭДЭД ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГ ОЛГОХ ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Ерөнхий мэдээлэл


“Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Иргэдийн амгалан тайван амьдрах орчинг бүрдүүлж, тогтвортой, хариуцлагатай, мэргэшсэн төрийн албыг чадавхижуулан, ил тод, нээлттэй, шударга, эрх тэгш, авлига, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хүргэн, хууль дээдэлсэн засаглалыг бэхжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэнтэй холбогдуулан “Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

“Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт чанд сахилга бат, дэг журамд суурилсан хүнлэг, иргэндээ ээлтэй, улсдаа түшигтэй, хууль хэлбэрэлтгүй мөрдөгдсөн хуулийн байгууллагыг бэхжүүлэх зарчмыг хэрэгжүүлэхээр тусгасан.

### Өнөөгийн байдал

Энэхүү ажлын хүрээнд иргэдээс “Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанар, албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүйн байдал, иргэдэд эрх зүйн талаарх мэдээлэл хэрхэн хүрч байгааг тодорхойлох” судалгааг 250 иргэнээс авлаа.

“Хуулийн байгууллагыг ямар байгууллагаар төсөөлж байна вэ?” гэсэн асуулга авахад цагдаа, шүүхээр төсөөлж байгаа нь дараах үзүүлэлтээс харагдаж байна.



Хуулийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс сэтгэл дундуур, сэтгэлд хүрээгүй гэсэн үнэлгээг дийлэнх олонх нь өгсөн байгаа нь иргэд хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа, онцлогийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь доорх үзүүлэлтүүдээс харагдаж байна.



Мөн хуулийн байгууллагуудаар үйлчлүүлэхэд хүндрэл учирдаг эсэх асуулгад дийлэнх олонх буюу 65% нь “тийм” гэсэн хариултыг өгсөн байна.

Хуулийн байгууллагуудын талаарх таны сэтгэгдэл гэсэн нээлттэй асуулганд дараах байдлаар сэтгэгдлээ ирүүлсэн байна. Үүнд:

- Ёс суртахуун, харьцааны хувьд доголдолтой
- Хүнд сурталтай
- Гар хардаг
- Мэдлэг, ур чадвар муу
- Залуу боловсон хүчин байхгүй
- Иргэддээ хүрч ажилладаггүй
- Үйл ажиллагаа нь ойлгомжгүй
- Хуулийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу.

Мөн хуулийн байгууллагад ажилладаг албан хаагчдаас тус хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан нээлттэй асуулгаар санал авсан бөгөөд нийт 110 албан хаагчид хамрагдсан бөгөөд албан хаагчдын зүгээс ёс зүй, харилцаа хандлага, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах асуудлыг боловсронгуй болгох, иргэдэд хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг тайлбарлан таниулах үйл ажиллагааг хүртээмжтэй зохион байгуулах гэсэн санал түлхүү ирүүлсэн байна.

Иргэд, албан хаагчдаас авсан мэдээллээ харьцуулан судалж үр дүнг нэгтгэхэд ихээхэн сөрөг үр дүнг гарч байгаа нь иргэдийн зүгээс албан хаагчид ёс зүй муутай, харилцааны соёлгүй, хүнд сурталтай, тодорхойгүй, чирэгдэл ихтэй, хуулийн

байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, тэдгээр байгууллагуудаар үйлчлүүлэхэд иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээлэл хомс, албан хаагчдын зүгээс ч харилцаа, хандлагаа өөрчлөх, ур чадвар, ёс зүйгээ дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Иймд хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, иргэдэд хууль зүйн салбарын тухай ойлголт, хуулийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог, тус байгууллагуудаар үйлчлүүлэхэд хууль, эрх зүйн талаарх мэдлэг мэдээллийг илүү хүртээмжтэй болгох шаардлага тулгараад байгаа тул хууль зүйн салбарын нийт албан хаагчид болон иргэдийг хамруулсан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

**Зорилго:** Хууль зүйн салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Хөтөлбөрийн зорилгыг хангах хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.**

Зорилт.1.Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх.

Зорилт.2. Хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах.

Зорилт.3. Хууль зүйн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх.

Зорилт.4. Хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.

#### **Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат:**

Хөтөлбөрийг 2017-2020 онд 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргаар жил бүр батлуулан хэрэгжүүлнэ.

### **Гурав. Хөтөлбөрийнхэрэгжүүлэх арга хэмжээ**

#### **Зорилт.1. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх.**

##### Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүргэх.

2. Хуулийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг иргэдэд мэдээллийн хэрэгслээр сурталчлах, таниулах

3. Хуулийн байгууллагуудад “Иргэдээ сонсьё” аян зохион байгуулах.

***Зорилт.2. Хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах.***

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Албан хаагчдад ёс зүй, харилцаа, сэтгэл зүйн чиглэлээр мэргэжлийн сургагч багш нартай хамтран сургалт, уулзалт зохион байгуулах.

***Зорилт.3.Хууль зүйн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх.***

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах.

2. “Албан хаагч солилцооны хөтөлбөр”-ийг нийслэл, орон нутгийн бусад хуулийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3. Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, иргэдэд хуулийн зүйл заалтыг зөв тайлбарлаж, зөвлөгөө өгч чаддаг чадвартай болгох

4. Албан хаагчдын дунд ажил мэргэжилтэй нь холбоотой гарсан хууль, дүрэм, тогтоол, шийдвэр хэрхэн мэдэж байгааг бататгах зорилгоор оюуны тэмцээн уралдааныг зохион байгуулах

5. Терроризмтэй тэмцэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах

***Зорилт.4. Хуулийн байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулах.***

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хуулийн байгууллагуудын дунд туршлага солилцох уулзалт, зөвлөгөөнийг тогтзохион байгуулах.

2. Онол-практикийн бага хурал зохион байгуулах

3. Хуулийн байгууллагуудын дунд спортын тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулах.

### **Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт**

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангах бөгөөд шаардлагатай төсвийг аймгийн

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тусгана.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 4 жилийн хугацаанд нийт 40,4 сая төгрөг шаардагдана.

#### **Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.


2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хууль, эрх зүйн хэлтэс хагас, бүтэн жилээр Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

3. Аймгийн Засаг дарга жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, жилийн эцэст үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлтүүд	Өнөөгийн түвшин 2016 он	Тоон үзүүлэлт	Зорилтод түвшин /он/				Үр нөлөө 2017-2020	
				2017	2018	2019	2020		
1	Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ /тоогоор/	1	46	10	11	12	13	Иргэдэд хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа явуулснаар иргэдийн хуулийн байгууллагуудаар үйлчлүүлэх хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, иргэд, хуулийн байгууллагуудын хоорондын үл ойлголцол буурсан байна.	
2	Хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ /тоогоор/	-	26	5	6	7	8	Хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага дээшилж, иргэдийн дундах сөрөг хандлага багасч, иргэд, байгууллага хоорондын үл ойлголцол буурсан байна.	
3	Хууль зүйн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг сайжруулах арга хэмжээ /тоогоор/	Сургалтын тоо	-	18	3	4	5	6	Хууль зүйн салбарын албан хаагчдын мэргэшил, ур чадвар дээшилж, өөрийгөө хөгжүүлэх арга барилд суралцаж, албандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж бүрдэнэ.
		Хамрагдсан албан хаагчдын тоо	-	100%	70%	70%	70%	100%	
4	Хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ /тоогоор/	1	38	8	9	10	11	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна.	

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 12 сарын 22 өдрийн  
73 дугаар тогтоолын 02 хавсралт



**ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ИРГЭДЭД ЭРХ  
ЗҮЙН МЭДЛЭГ ОЛГОХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Санхүүжилт	Хэрэгжүүлэх байгууллага, төрийн байгууллагууд
<b>Зорилт.1. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх.</b>							
1	Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах	1. Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүргэх	2017-2020	Зохион байгуулах сургалтын тоо 16 удаа  Хамрагдсан иргэдийн тоо 1500 хүн	Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	4,5 сая	Аймгийн ЗДТГ Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Шүүх
		2. Хуулийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг иргэдэд мэдээллийн хэрэгслээр таниулах, сурталчлах	2017-2020	Хэвлэл мэдээллийн байгууллагаар хүргэсэн мэдээллийн тоо-20 удаа	Иргэд Хуулийн байгуулла-гуудын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болсон байна.	4,5 сая	Аймгийн ЗДТГ- Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагууд-тай хамтран
		3. Хуулийн байгууллагуудад “Иргэдээ сонсьё” аяныг зохион байгуулах.	2017-2020	Зохион байгуулах аяны тоо- 4 удаа	Нийт иргэдийн 50 хувьд хүрч үйлчилсэн байна.	3,0 сая	Аймгийн ЗДТГ- Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагууд хамтран



<b>Зорилт.2. Хууль зүйн салбарын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах.</b>							
2	Албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг үе шаттай зохион байгуулах	1. Албан хаагчдад ёс зүй, харилцаа, сэтгэл зүйн чиглэлээр мэргэжлийн сургагч багш нартай хамтран үе шаттай сургалт, уулзалт зохион байгуулах.	2017-2020	Сургалтын тоо-16 Хамрагдсан албан хаагчдын тоо-100 хувь	Ёс зүйн зөрчил буурсан байна.	8,0 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран
<b>Зорилт.3. Хууль зүйн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх.</b>							
Хуулийн байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх	1 .Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, иргэдэд хуулийн зүйл заалтыг зөв тайлбарлаж, зөвлөгөө өгч чаддаг чадвартай болгох		2017-2020	Зохион байгуулсан сургалтын тоо -16 удаа	Хуулийн талаар зөвлөгөө өгөх чадвартай болсон байна	1.0 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран
	2. “Албан хаагч солилцооны хөтөлбөр”-ийг нийслэл, орон нутгийн бусад хуулийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		2017-2020	Зохион байгуулах солилцоо-4 удаа Хамрагдсан албан хаагчдын тоо-30	Албан хаагчид бусад хуулийн байгууллагын амжилттай туршлагад суралцсан байна.	6,0 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран
	3. Албан хаагчдын дунд ажил мэргэжилтэй нь холбоотой гарсан хууль, дүрэм, тогтоол шийдвэр хэрхэн мэдэж байгааг бататгах зорилгоор мэтгэлцээн, аст, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулах		2017-2020	Зохион байгуулах арга хэмжээний тоо-4 удаа	Албан хаагчдын идэвхи санаачлага сайжирч, ажлын ур чадвар дээшилнэ.	2.0 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран

		4. Албан хаагчдыг мэргэшүүлэх, магистр, докторын сургалтанд хамрагдах боломж нөхцлөөр хангах	2017-2020	Нийт албан хаагчдад магистр, докторын эзлэх хувь нэмэгдсэн байна.	Мэргэжлийн зэрэгтэй, мэргэшсэн албан хаагчдын тоо нэмэгдсэн байна.	Шаардахгүй	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран
		5.Терроризмтэй тэмцэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	2017-2018	Хуулийн байгууллагуудын албан хаагчид, 200 иргэд хамрагдсан байна.	Терроризмтэй тэмцэх үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	3.0 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн хэлтэс

**Зорилт.4. Хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.**

4	Хуулийн байгууллагуудын дунд туршлага солилцох арга хэмжээг тогтмол зохион байгуулах.	1. Хуулийн байгууллагуудын дунд туршлага солилцох уулзалт, зөвлөлгөөнийг тогтмол зохион байгуулах.	2017-2020	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо-16 удаа - Хамрагдсан албан хаагчдын тоо-50 хувь	Хуулийн байгуулла-гуудын уялдаа холбоо сайжирсан байна.	2.4 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран	
		2. Онол-практикийн бага хурал жилд 1 удаа зохион байгуулна.	2017-2020	4 удаа зохион байгуулсан байна.	Албан хаагчдын онолын мэдлэг өргөжиж, мэргэжлийн ур чадвар дээшилнэ.	2.5 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран	
		3. Хуулийн байгууллагуудын дунд спортын тэмцээн уралдаан зохион байгуулах.	2017-2020	4 удаа зохион байгуулсан байна.	Хуулийн байгуулла-гуудын уялдаа холбоо сайжирч, албан хаагчдын хамтын үйл ажиллагаа сайжирсан байна.	3.5 сая	ЗДТГ-Хууль, эрх зүйн хэлтэс, хуулийн байгууллагуудтай хамтран	
<b>Нийт</b>							<b>Нийт 40.4 сая</b>	